



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 09

Эрдэнэт

“Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай”
хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 “е”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөрийг нэгдүгээр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр нэмэгдүүлэх арга хэмжээ авч, улс болон орон нутгийн төсөвт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 2 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

3.Энэ хөтөлбөрийн хүрээнд өөрт хамаарах зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулагдаж буй арга хэмжээнд идэвхтэй оролцож хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг нийт иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжид уриалсугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ